

БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ

ЗУРАГ ТӨСЛИЙН БАРИМТ БИЧГИЙН
МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

2018 оны 09 дугаар сарын 07 өдөр

Дугаар 50-0375/2018

Улаанбаатар-15171
Утас: 323022, 328097
Факс: 976-11-320338

Объектын нэр, байршил:	Дундговь аймгийн Дэлгэрцогт суманд баригдах "250 хүний суудалтай соёлын төвийн барилга"-ын төсөв		
Хүчин чадал:	Цутгамал төмөр бетон арагт бүтээцтэй, блок дүүргэгчтэй, цутгамал төмөр бетон хучилттай, тэнхлэгээрээ 30.0 x 18.0 м, зоорьгүй 2 давхар		
Захиалагч:	Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын яам		
Санхүүжилтийн эх үүсвэр:	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар		
Зураг төслийн ерөнхий гүйцэтгэгчийн нэр	"Аслаан" ХХК		
Регистрийн дугаар:	РД: 5147425		
Тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа:	2021.03.22		
Ажилбарын төрөл:	1.2.4, 1.2.6, 1.3.1, 1.3.2, 1.3.3, 1.2.1		
Зураг төсөл боловсруулах үндэслэл:			
Зураг төсөл боловсруулах үндэслэл:	Аймгийн Засаг даргын 2009 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 141 дугаар захирамж		
Зураг төсөл боловсруулах гэрээ, баталсан албан тушаалтан:			
Техникийн нөхцөлүүд:			
Техникийн нөхцөлүүд:	Олгосон байгууллага	Дугаар, огноо	Хүчинтэй байх хугацаа
Шаардлагагүй			
Зураг төслийн бүрэлдэхүүн:			
Зургийн бүрдэл:	Зураг төслийн гүйцэтгэсэн байгууллагын нэр:	Шалгасан экспертийн нэр:	
Барилгын төсөв	"Аслаан" ХХК Тэргүүлэх төсөвчин А.Уранчимэг	Д.Санж	
Ерөнхий дүгнэлт: /Засгийн газрын 2009 оны 204 дүгээр тогтоолын 7 дугаар зүйлээс/			
Барилга байгууламжийн техникийн ерөнхий өгөгдөл	Барилга байгууламжийн техникийн ерөнхий өгөгдөл: Дундговь аймгийн Дэлгэрцогт суманд баригдах "250 хүний суудалтай соёлын төвийн барилга"-ын зураг төсөл, төсөв нь Газрын харилцаа, барилга, геодези, зураг зүйн газрын зураг төсөл, хайгуул, судалгааны ажлын улсын экспертизийн 2012 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 459/2012 тоот дүгнэлтээр албажсан байна. Тус театрын барилгын ажлыг дуусгахаар Дундговь аймгийн 2018 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд суусан тул 2012 онд батлагдсан төсвийг дахин магадлал хийлгэх хүсэлтийн төсөвт өөрчлөлт оруулж байгаа болно.		

Уг барилга нь тэнхлэгээрээ 30.0 х 18.0 м хэмжээтэй, зорьгүй 2 давхар барилга байна.
 Барилгын үндсэн хийц бүтээц нь:
 Суурь: Цутгамал төмөр бетон баганан суурь.
 Даацын үндсэн бүтээц: Цутгамал төмөр бетон арагт бүтээцтэй
 Гадна хана: 360 мм зузаан хөнгөн блок дүүргэгчтэй, 100 мм зузаан хөөсөнцөр хавтан дулаалгатай.
 Хучилт, дээвэр: цутгамал төмөр бетон хучилттай байхаар тус тус тооцсон байна.

Боловсруулсан зураг төслийн сонгосон шийдэл, магадлалын явцад хийсэн нэмэлт, өөрчлөлтөөс шалтгаалах үр дүнгийн талаархи тодорхой санал, дүгнэлт:

Зураг төслийн төлөвлөлт, техникийн шийдлийг холбогдох орон тооны бус эксперт шалгаад:
 Барилгын төсөв: Гал, ариун цэврийн байгууллагатай зөвшилцсөн, зураг экспертизээр батлагдсан, "Барилгын төсөв зохиох дүрэм" БНБД81-95-12-ын дагуу хийсэн, довжоо болон гадна хайсны материалын үнийг 1 кг-ийг 4000 төгрөгөөр тооцсоныг хянаж засварлах, зарим ажлын механизмын тооцоонд цамхагт кран тусгагдсаныг хасаж тооцох, гадна дулааны худаг хийх ажлын үнэлгээг 21-230-11-ээр үнэлсэн байна зөв үнэлгээг сонгох, дулааны сувгийн хавтан зурагт ГСХ-7-оор тусгагдсаныг төсөвт ГСХ-5-аар тооцсон тоо хэмжээ зургаас зөрүүтэй байгааг хянаж харуулах, гадна дулаан, цэвэр, бохир усны шугамын газар шорооны ажлын тоо хэмжээг хянаж засах, гадна цахилгааны ажлын цалингийн тооцоо төсөвт байхгүй байна, зурагт септик ба шүүрүүлэх суваг тусгагдсан байна төсөвт ороогүй байгааг тодруулах, төсвийн нүүр хуудас, тайлбар бичгийг БХБ-ын Сайдын 2018 оны 43 дугаар тушаалд заасан шинэ журмаар хийх. Экспертийн өгсөн үүрэг даалгаврын дагуу зураг төсөлд засвар өөрчлөлтүүдийг хийсэн байна.

Эдийн засгийн үр ашгийн талаархи дүгнэлт:

Дундговь аймгийн Дэлгэрцогт суманд баригдах "250 хүний суудалтай соёлын төвийн барилга"-ын төсөв нь 2012 оны 459/2012 тоот дүгнэлтээр 940 967 327 /есөн зуун дөчин сая есөн зуун жаран долоон мянга гурван зуун хорин долоо/ төгрөгөөр баталгаажсан төсвийг "Барилгын үнэ бүрдлийн үндсэн дүрэм" /БНБД 81-94-12/, "Барилгын төсөв зохиох дүрэм" /БНБД 81-95-12/, ЗТБХБС-ын 2018 оны 18 дугаар тушаалаар батлагдмсагн "Машин цагийн үнэ", мөн сайдын 2009 оны 263 дугаар тушаалаар батлагдсан "Барилгын ажилчдын тарифт цалингийн жишиг" -ийн дагуу дахин шинэчлэн тооцож гаргасан бөгөөд БХБС-ын 2016 оны 203 дугаар тушаалаар батлагдсан "Барилга байгууламжийн нэгж хүчин чадлын жишиг үнэлгээг хэрэглэх дүрэм" /БД 81-106-16/-ийн дагуу жишиг үзэхэд холбогдох норм дүрмийн дагуу тооцсон байна.

Дундговь аймгийн Дэлгэрцогт суманд баригдах "250 хүний суудалтай соёлын төвийн барилга"-ын барилга угсралтын ажлын төсөвт өртгийн нэгдсэн товчоо

№	Барилгын ажлын			Барилгын	
	Төрөл	Тодорхойлолт	Төсөвт өртөг /төг/	Хүчин чадал	нэгж өртөг /төг/
1	а/ Барилга угсралтын ажил				
1.1	Барилга	Цутгамал төмөр бетон арагт бүтээцтэй, блок дүүргэгчтэй, цутг	892 947 885,0	1 080,0	826 803,6
1.2	Дотор халаалт салхивч	бүтээцтэй, блок дүүргэгчтэй, цутг	45 497 018,0	1 080,0	42 126,9

Төсөв: Эксперт нь Дундговь аймгийн Дэлгэрцогт суманд баригдах "250 хүний суудалтай соёлын төвийн барилга"-ын төсөвт өртгийг 1 237 200 354 (нэг тэрбум хоёр зуун гучин долоон сая хоёр зуун мянга гурван зуун тавин дөрвөн) төгрөгөөр тэнгэсэн байна.

Барилгын тухай "Монгол Улсын хуулийн /шинэчилсэн найруулга 2016 он/ 38.1.2-т "барилга байгууламжийн зураг төслийн холбогдох хэсгийг боловсруулсан зохиогч тухайн зураг төслийг баталгаажуулан, мэргэжлийн хариуцлага хүлээх", 38.1.3-т "зураг төсөл зохиогч хуулийн этгээд барилга байгууламжийн зураг төслийг хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцсэн эсэхэд хяналт хийж баталгаажуулан, хариуцлага хүлээх", 39.4-т "Эксперт барилга байгууламжийн зураг төслийн холбогдох хэсэгт магадлалын дүгнэлт гаргаж, мэргэжлийн хариуцлага хүлээх", 39.5-д заасны дагуу "Экспертийн эрх бүхий хуулийн этгээд барилга байгууламжийн зураг төслийг хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцсэн эсэхийг нотолж, техникийн шийдлийн талаархи дүгнэлт гаргаж, хариуцлага хүлээнэ".

Дундговь аймгийн Дэлгэрцогт суманд баригдах "250 хүний суудалтай соёлын төвийн барилга"-ын төсөвт "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм", "Барилгын үнэ бүрдлийн үндсэн дүрэм" /БНБД 81-94-12/, "Барилгын төсөв зохиох дүрэм" /БНБД 81-95-12/, тус тус үндэслэн магадлал хийх ажлыг зохион байгуулж, ерөнхий дүгнэлт бичсэн болно.

Ерөнхий дүгнэлт нь экспертийн 5 хуудас хавсралт дүгнэлтийн хамт хүчинтэй.

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛД МАГАДЛАЛ
ХИЙХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛСАН:

БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ЗАХИРАЛ

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН
ЗУРАГ ТӨСӨЛ, МАГАДЛАЛЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН
ЗУРАГ ТӨСӨЛ, МАГАДЛАЛЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Ц.АМАРСАНАА

Э.ХАНГАЛ

Д.САРАНТУЯА


Зураг төслийн баримт бичгийн
МАГАДЛАЛЫН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ №1

ЗУРАГ ТӨСЛИЙН БҮРДЭЛ ХЭСГИЙН ТЭВ /Барилгын төсөв:/

250 суудалтай соёлын төв

2018 оны 04 сарын 18 өдөр

Д/д	Утга	Тайлбар
1	Объектын нэр	250 суудалтай соёлын төв
2	Объектын байршил, хүчин чадал	Дундговь аймаг, Дэлгэрцогт сум, 1-р баг
3	Зураг төслийн байгууллага	"Аслаан" ХХК
4	Зургийн шифр	08/2018
5	Хуудасны тоо	105
6. Дүгнэлтийн товч утга: /Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 204 дүгээр тогтоолын 7-р зүйлээс/		
1	7.5.1. барилга байгууламжийн байршил тогтоосон шийдвэр, архитектур төлөвлөлтийн болон зураг төсөл боловсруулах даалгавар, эх загвар зураг, байгаль, цаг уурын ерөнхий өгөгдлүүд, техникийн нөхцөл, холбогдох мэргэжлийн байгууллагатай зөвшилцсөн байдал;	Гал, ариун цэврийн байгуулагатай зөвшилцсөн. зураг экспертизээр батлагдсан
2	7.5.2. барилга, байгууламжийн архитектур төлөвлөлт, бүтээц, инженерийн хангамжийн шийдэл нь дагаж мөрдөж байгаа норм, дүрэм, стандарт, технологийн даалгавар, тоног төхөөрөмжийн паспорт, инженер-геологийн судалгааны дүгнэлт, техникийн нөхцөлийн дагуу зохиогдсон эсэх;	Бүгд норм дүрмийн дагуу хийгдсэн
3	7.5.3. барилга байгууламжийн байршил, хот төлөвлөлт, инженер-геологийн нөхцөл, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, сонгосон байршил, талбайн инженерийн хангамжийн хувилбар, харьцуулсан тооцоо, сонгосон хувилбарын талаархи дүгнэлт;	
4	7.5.4. зураг төслийн төлөвлөлт, техникийн шийдэл нь материал, түлш, эрчим хүч, усны нөөцийг хэмнэлттэй ашиглах нөхцөлийг бүрдүүлсэн байдал;	

д/д	Утга	Тайлбар
5	7.5.5. хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагаа, орчны эрүүл ахуйн байдалд тавигдах стандартын шаардлага болон норм, дүрмийг баримталсан байдал;	Хөдөлмөр хамгаалалын зардал төсвийн нормын дагуу тусгагдсан
6	7.5.6. хөгжлийн бэрхшээлтэй иргэд ажиллаж, амьдрах нөхцөлийг хангасан төлөвлөлтийн шийдлийг тусгасан байдал;	
7	7.5.7. хөрсний бохирдлоос хүрээлэн байгаа орчныг хамгаалах, үйлдвэрийн бохирдсон усыг цэвэрлэж ашиглах боломж, гадагш хаяж байгаа бохирдсон агаар, ус норматив үзүүлэлтийг хангаж буй эсэх;	
8	7.5.8. инженерийн шугам сүлжээний уртын дагуухь төлөвлөлтийн оновчтой шийдэл;	Нормын дагуу хийгдсэн
9	7.5.9. барилга байгууламжийн гаднахь ерөнхий төрх, архитектурыг хот төлөвлөлтийн шаардлагад нийцүүлэн орчны барилга байгууламжтай уялдуулсан байдал, эзэлхүүн болон талбайг үр ашигтай төлөвлөсөн байдал;	Уялдуулсан
10	7.5.10. барилгын ажлын зохион байгуулалтын болон барилга байгууламжийг буулгах, задлах ажил гүйцэтгэх зураг төсөлд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлагыг тусгасан байдал.	Байхгүй
11	7.6. Магадлалын дүгнэлтэд хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийг үндэслэн төлөвлөлт, техникийн үндсэн шийдэл, эдийн засгийн үр ашиг, мөн хөгжлийн үнэлэлт өгч, техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөлд нэмж тусгах буюу хасах, өөрчлөх асуудлын талаар товч, тодорхой тусгана.	Төсөв зохиох дүрмийн дагуу хийгдсэн БНБД 81-95-12
Дүгнэлт бичсэн Эксперт № 9-18		 <p>2018 оны 04 сарын 18 өдөр</p>

Зураг төсөл хайгуул судалгааны ажилд улсын экспертиз хийх, экспертизийг шалгаруулах түүнийг ажиллах журмын 2 дугаар хавсралт.

.....ТООТ УЛСЫН ЭКСПЕРТИЗИЙН ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТИЙН ХАВСРАЛТ.

2018 оны 04 сарын 12 өдөр

"Аслаан" ХХК Захирал Ж.Банзрай
/Гүйцэтгэсэн байгууллага, инженер/


Дундговь аймаг Дэлгэрцогт сумын Соёлын төвийн барилгын ажлын төсөв
/объектын нэр, шифр/

Төсөв: Тэргүүлэх төсөвчин А.Уранчимэг

/Зургийн марк/

/зураг, тооцооны хуудасны тоо/

Зураг шифр Төсөвт өртөг 1,239,198,519 төгрөг

№	Дүгнэлтийн товч утга	Тайлбар
1.	1. Довжоо болон гадна хайсны материалын үнийг 1 кг-ийг 4000 төгрөгөөр тооцсоныг хянаж засварлах 2. Зарим ажлын механизмын тооцоонд цамхагт кран тусгагдсаныг хасаж тооцох 3. Гадна дулааны худаг хийх ажлын үнэлгээг 21-230-11-ээр үнэлсэн байна зөв үнэлгээг сонгох 4. Дулааны суваг, өнцгийн цутгамал хийцийн тоо хэмжээг зурагт заасан альбомын дагуу тооцох 5. Дулааны сувгийн хавтан зургат ГСХ-7-оор тусгагдсаныг төсөвт ГСХ-5-аар тооцсон, тоо хэмжээ зургаас зөрүүтэй байгааг хянаж залруулах 6. Гадна дулаан, цэвэр, бохир усны шугамын дулаалгын үнэлгээг буруу сонгосныг засах /24-120-04-өөр үнэлэх/ 7. Гадна бохир усны шугамын газар шорооны ажлын тоо хэмжээг хянаж засах 8. Гадна цахилгааны ажлын цалингийн тооцоо төсөвт байхгүй байна 9. Зурагт септик ба шүүрүүлэх суваг тусгагдсан байна. Энэ ажил төсөвт ороогүй байгааг тодруулах 10. Төсвийн нүүр хуудас, тайлбар бичгийг БХБ-ын Сайдын 2018 оны 43-р тушаалд заасныг журмаар хийх	- 2000 төгрөгөөр ТАСВИН ТУСГАА Х.А.САЛАР ТАРЧСААР Ч.О.САЛОН ЗАСААН ЗУРГААНЫ ДАГУУ ТУСГАА ГСХ-7 БАЛГАН ЗАСАВ 24-120-04 - ӨӨР УРААН ЗАСАВ - ЗАСАВ - ТАРАВТ ТУСГАА - ЦАХИЛГАА ТУСГАА - ЗАСААН
2	Дүгнэлт бичсэн. Эксперт Барилгын үнэлгээ, норгон	 Д.Санж

Тайлбар.

1. Ерөнхий дүгнэлтгүй бол хүчингүй, дүгнэлтийн товч утгыг компьютерээр бичиж , зэрэг дэвийн тамгаа дарж баталгаажуулна.
2. Экспертийн бичсэн дүгнэлтийн дагуу зураг төслийг гүйцэтгэсэн инженер нь холбогдох засвар өөрчлөлтийг хийж экспертээр дахин хянуулж гарын үсэг зурж баталгаажуулна.



**ХУДАЛДАА, ҮЙЛДВЭРЛЭЛ,
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ “ГАН-ИЛЧ” ХХК**

212700 Мандалговь, Дундговь аймаг
Утас: 7059-3725, Факс: 7059-3725

2019.12.09 № В/74
танай _____-ны № _____-т

ДЭЛГЭРЦОГТ СУМЫН СОЁЛЫН
ТӨВИЙН БАРИЛГА-Д

Техникийн нөхцөл олгох тухай

Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын засаг даргын 2019 оны 11 дүгээр сарын 25-нд ирүүлсэн албан хүсэлт, өргөдөл, байршлын схем, фото зураг зэргийг үндэслэн Дэлгэрцогт сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт буюу хуучин “Соёлын төв”-ийн зүүн талд баригдах 30x18,4 харьцаатай 3920 м³ эзлэхүүнтэй “Соёлын төв”-ийн барилгад дараах нөхцөлүүдийг хангасан тохиолдолд дулаанаар хангах боломжтой гэж үзэн зөвшөөрөл олгож байна.



1. Тус барилга нь Дэлгэрцогт суман дахь манай компаний харьяаллын халаалтын зуухнаас дулаанаар хангагдах ба Халаалтын зуухны хойно байрлах ДХ-1-д 2x100 мм-ийн диаметртэй шугаманд 2x65 мм-ийн диаметртэй шугамаар огтлол хийж холболт хийхийг зөвшөөрөв.
2. Дулааны худаг, суваг, узель болон бусад хийцийг БНБД-д заасны дагуу хийж бөмбөлгөн хаалт тавих, хаалтны хоёр талыг фланец холболтоор холбох ба гагнагдах төгсгөлтэй арматур угсрахыг хориглоно.
3. Угсралтын ажлыг ажлын зурагтай нягт уяалдуулан гүйцэтгэх ба дулааны шугам сүлжээний барилгын ажлыг гүйцэтгэх норм нормативын шаардлагад нийцэж байгаа талаар манай мэргэжлийн хүмүүсийн тавьсан шаардлагыг хэрэгжүүлж ажиллах.
4. Барилгын оролтын дулааны зангилгааг стандарт норм дүрмийн дагуу угсарч шаардлага хангасан хянах, хэмжих хэрэгслүүдээр тоноглох ба үзлэг үйлчилгээ хийх зориулалт бүхий тусгай өрөөтэй байх
5. Тус дулааны шугам нь зам талбай, ногоон байгууламжийг дайран гарах бол ажил гүйцэтгэсний дараа тэдгээрийг болон орчны тохижилтыг нөхөн сэргээсэн байх
6. Зураг төсөл хийх байгууллагын мэргэжлийн хүмүүс газар дээр нь ирж тодотгол хийж манай өгсөн зөвшөөрлөөс өөр байдлаар хийх санал гаргавал уг асуудлаар манай байгууллагатай зөвшилцөж техникийн нөхцөлийг шинэчилж болно.
7. Дулааны шугаманд огтлол хийж холболт хийхдээ хангагч байгууллагад заавал мэдэгдэх.
8. Дулаанаар хангах хангагдах гэрээг байгуулсаны дараа системийн дүүргэлт хийж халаалтын үйл ажиллагааг эхлүүлнэ.
9. Энэхүү зөвшөөрөл нь олгосон өдрөөс 2 жилийн хугацаанд хүчинтэй байх ба дээрхи нөхцөлүүдийг хэрэгжүүлээгүй тохиолдолд хүчингүйд тооцох болно.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



О.ГАНХУЯГ

Дэлгэрцогт сумын "Соёлын төв"-ийн барилгын гадна шугам сүлжээний тойм зураг





ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧЭЭР ХАНГАХ ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

2019 оны 11 дугаар сарын 28-ний өдөр

№2019/83

Мандалговь хот

1.Техникийн нөхцөл хүссэн хуулийн этгээд болон байгууллага

*Дундговь аймаг Дэлгэрцогт сум
Соёлын төв*

2.Хэрэглэгчийн хаяг:

*Дундговь аймаг Дэлгэрцогт сум
Соёлын төв*

3. Хэрэглэгчийн байршил, зэрэглэл:

Дундговь аймаг Дэлгэрцогт сум

III зэрэглэл

4. Ажил үйлчилгээний зориулалт

Төрийн үйлчилгээ

5. Техникийн нөхцөл олгох үндэслэл:

*2019 оны 11-р сарын 25-ны өдрийн
Албан тоот*

6. Суурилагдсан чадал:

40 кВт

7. Холбогдох цэг:

*7.1 АТП-34 10/0,4кВ-ын дэд станцын 0,4кВ-ын фидер №3 Төв гаргалгаа Тулгуур №72 щит №37-оос АВВГ/З*35+1*16/-аас багагүй хөндлөн огтлол бүхий кабелиар авах.*

8.Тоолуур хэмжих хэрэгсэл:

8.1 Монгол улсын Стандартчилал хэмжилзүйн үндэсний төвөөс загварын туршилтанд орж, ашиглахыг зөвшөөрч баталгаажуулсан өндөр нарийвчлалтай 3 фазын (5-100)А-ын электрон тоолуур, 3 фазын 100А-ын автоматыг стандартын дагуу монтажлан эзэмшлийн заагт байршуулна.

9. Тусгай заалтууд:

9.1 Шинээр баригдах объектын цахилгаан хангамжийн ажлын зургийг эрх бүхий байгууллагаар хийлгэн техникийн нөхцөл олгогчоор хянуулна.

9.2 Шинээр баригдах ЦДКШ, байршлын зураг, трассын схемийг Дундговь ЦТС, Салбарын инженер техникийн ажилчидтай хамтран гаргана.

9.3 0.4кВ-ын ерөнхий цитний газардуулгын эсэргүүцлийг "Цахилгаан байгууламжийн дүрэм"-ийн 1.6.36-д заагдсаны дагуу 4 Ом-оос ихгүй байхаар газардуулсан байна.

9.4 Хэрэглэгчийн баригдах объект нь бусдын эзэмшлийн газар нутаг, инженерийн байгууламжийг дайрч байвал холбогдох эзэмшигчээс зөвшөөрөл авна. Мөн объектын хамгаалалтын зурвас, газрын зөвшөөрлийн талаар холбогдох албан газраас нь зөвшөөрөл авна.

9.5 Шинээр хийгдэх цахилгаан угсралт, монтажийн ажилд хүчдлийн түвшингийн $\pm 5\%$ -ийн хэлбэлзэлд ажиллах, Монгол орны цаг уурын нөхцөлд зохицсон, экологид сөрөг нөлөөлөлгүй орчин үеийн шинэ найдвартай тоног төхөөрөмж суурилуулна.

9.6 Цахилгааны оруулга, гаргалгын кабель шугам, барилгын дотор монтаж, угсралтын ажлыг "Эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрөл"-тэй мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.

9.7 Шинээр баригдах шугам тоноглолын барилга угсралтын ажлыг норм дүрмийн дагуу гүйцэтгэж, шаардлагатай туршилт хэмжилтийг "Дундговь ЦТССалбар-аар хийлгэж, холбогдох хүчин төгөлдөр акт, протоколыг бүрдүүлнэ.

10. Дор дурьдсан техникийн даалгавар, хууль дүрмийг мөрдөх:

10.1 Техникийн нөхцөлд тусгагдсан эрчим хүчний барилга угсралтын ажлыг гүйцэтгэсний дараа "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 4.22, 4.23-р заалт, "БЗӨБЦТС" ТӨХК-ийн "Цахилгаан түгээх сүлжээнд шинээр холбогдох объектыг ашиглалтанд хүлээн авах журам"-ын дагуу цахилгаан түгээх сүлжээнд холбогдоно.

10.2 Цахилгаан тоноглол болон агаарын шугам, кабель шугамын ашиглалт үйлчилгээний талаар "БЗӨБЦТС ТӨХК"-ийн Дундговь ЦТССалбарын шуурхай үйлчилгээний хэсэгтэй, цахилгаан эрчим хүчний тооцооны талаар Хангах хэсэгтэй тус тус гэрээ байгуулж ажиллана.

10.3 Хэрэглэгч нь Монгол улсын Эрчим хүчний тухай хуулийн 30.1.2 30.1.3 30.1.4 30.1.7 30.1.8-р заалтуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.

10.4 Хэрэглэгч нь өөрийн эзэмшлийн цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт аюулгүй ажиллагааг хариуцсан ажилтныг томилох бөгөөд шугам сүлжээний хамгаалалтын зурвасын дотор гэр, орон сууц, үйлдвэрлэлийн бус барилга байгууламж барих, шугам сүлжээ өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрснөөс бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

10.5 Хэрэглэгч нь "Эрчим хүчний тухай" хуулийн 30.1.3 дахь заалтын дагуу өөрийн эзэмшлийн цахилгаан тоног төхөөрөмжөөс бусад хэрэглэгчдийг тэжээх үүрэгтэй.

10.6 Цахилгаан эрчим хүч хэрэглэгч нь Монгол Улсын Эрчим Хүчний тухай хууль болон цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрмийн заалтуудыг дагаж мөрдөх үүрэгтэй.

10.7 Энэхүү техникийн нөхцлийн дагуу барилга угсралтын ажлыг хоёр жилийн хугацаанд хийж гүйцэтгэн сүлжээнд холбогдох бөгөөд энэ хугацаанд ажлыг хийгээгүй тохиолдолд дахин шинээр техникийн нөхцөл авна.

Комиссын дарга

Гишүүд

С.Энхбат /ГҮАХЕ Инженер/

Б.Батсүрэн /ХҮАХ Менежер/

Э.Энх-Амгалан /Засварын мастер/

Д.Нэргүй /Борлуулалтын инженер/

Н.Цэвэгдэлгэр /Ээлжийн ахлах инженер/



589

ДУНДГОВЬ АЙМГИЙН
САНХААГААРИЙН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

ДТ/11 11 07

Дугаар 07

Асартай

Газар эзэмшүүлэх тухай

Монгол улсын Газрын тухай хуулийн 21-р зүйлийн 4-ын 3, 33-р зүйлийн 1-д 1 дэх заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг: Сумын төвийн нутаг дэвсгэрт 2000 м² газрыг Соёлын төвд албан ёсоор зориулалтаар эзэмшүүлсүгэй.

Хоёр: Эзэмшил газрын хил заагийг тогтоон газрыг хүлээлгэн өгч, гэрээ байгуулан, гэрчилгээ олгож, гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын дарга М.Аззаяа-д даалгасугай.

Гурав: Газраа зориулалтын дагуу байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр ашигшиж, гэрээнд заасан үүргээ биелүүлж байхыг Соёлын төвийн эрхлэгч С.Тонцэцэгт үүрэг болгосугай.

ДАРГА

Н.ЗАГДХОРОЛ

Дундговь аймгийн Дэлгэрцогт сум

Нэгж талбарын дугаар: 4811000707

Хуулийн этгээдийн нэр: Соёлын төв

Ашиглалтын төрөл: эзэмших


Регистрийн дугаар: 9033513

ХАЯГ: Аймаг/Хот: Дундговь
Гудамж: Амардалай-2


Сум/Дүүрэг: Дэлгэрцогт
Тоот: 207

Баг/Хороо: 3-р баг

Кадастрын муж: 0110



Орчны тойм



Координатын систем:

WGS84/UTM 48N

EPSG: 32648

Нэгж талбар Масштаб = 1: 5000

№	X	Y	Урт
1	606062.29	5109035.81	49.93
2	606110.70	5109048.34	40.06
3	606120.72	5109009.61	49.93
4	606072.31	5108997.09	40.06

№ X Y Урт Дугаар Талбай

Талбайн хэмжээ: 2000,0 квадрат метр
Зург хэвлэсэн: /Хуучин/ Т.Хулан/
(Сумын газрын дарга)
Хянасан: /Б.Рэнцэндорж/
(Газрын удирдлагын хэлтсийн дарга)
48110000037

Зургын масштаб = 1:500 (1 сантиметрт 5 метр багтана)

Хэвлэсэн огноо: 2019-08-15



МОНГОЛ УЛС

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН
ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН
ГЭРЧИЛГЭЭ

Дугаар 000010201

Соёлын төв _____ / 9033513 /-д
 _____ (байгууллагын нэр) _____ (регистрийн дугаар)
 Сумын Засаг даргын захирамж 11 11 07
 _____ -ын 20 _____ оны _____ сарын _____ өдрийн _____ тоот
 (шийдвэр гаргагч) Дундговь Дэлгэрцогт 3-р баг
 шийдвэрийг үндэслэн _____
 _____ (аймаг, нийслэл) _____ (сум, дүүрэг) _____ (баг, хороо)
 Амардалай-2 207
 _____ хаягт
 _____ (гудамжны нэр) _____ (хашааны дугаар/ тоот)
 байрлах, нэгж талбарын 4811000707 2000.0 /0.2/
 _____ угаар бүхий _____ м.кв /га/ газрыг
 Урлаг, соёлын байгууллага
 _____ зориулалтаар
 7 _____ Э-0815000084
 _____ жилийн хугацаатай эзэмшүүлж, эрхийн улсын бүртгэлийн _____

дугаарт бүртгэж гэрчилгээ олгов.

ГАЗРЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН
БАЙГУУЛЛАГА / АЛБАН ТУШААЛТАН

СУМЫН ГАЗРЫН ДААМАЛ



_____ / Л.Хулан /
 _____ (гирын үсэг) _____ (нэр)

19 10 3
 20 _____ оны _____ сарын _____ өдөр

ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ТЭМДЭГЛЭЛ

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан, тамга
1	<div style="border: 1px solid black; width: 100%; height: 100%; position: relative;"> <div style="position: absolute; top: 10%; left: 10%; width: 80%; height: 10%; border: 1px solid black;"></div> <div style="position: absolute; top: 18%; left: 25%; width: 50%; height: 10%; border: 1px solid black;"></div> <div style="position: absolute; top: 54%; left: 10%; width: 80%; height: 10%; border: 1px solid black;"></div> </div>		

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Газар эзэмших эрхийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

Нэгж талбарын дугаар: 4811000707
 Улсын бүртгэлийн дугаар: Э-0815000084
 Гэрчилгээний дугаар:

ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ГАЗАР
 ЭЗЭМШҮҮЛЭХ ГЭРЭЭ

2019 оны 10 сарын 15 өдөр

№ 04819-2019/00050

Дундговь аймаг/хот Дэлгэрцогт
 сум/дүүрэг

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Газрын тухай хууль, Дундговь аймаг /нийслэл/-ийн Дэлгэрцогт дүүрэг /сум/-ын Засаг даргын 2011 оны 11 сарын 07 -ны өдрийн 04819- /67/2011 тоот шийдвэрийг үндэслэн газар эзэмшүүлэгчийг төлөөлж, Дундговь аймаг/хотын Дэлгэрцогт сум/дүүргийн Дундговь аймгийн Дэлгэрцогт сум-ын мэргэжилтэн Лувсандорж овогтой Хулан газар эзэмшигчийг төлөөлж Соёлын төв-ны Эрхлэгч Шар овогтой Отгонцэцэг нар энэхүү гэрээг байгуулав.

Хоёр. Гэрээний нөхцөл

2.1. Газар эзэмшигчид олгосон газрын нийт хэмжээ

2000 м2

Үүнээс:

Нэгж талбарын тодорхой хэсгийг эзэмших зориулалт	Тухайн зориулалтаар эзэмших газрын хэмжээ	Газар эзэмших хугацаа
Урлаг, соёлын байгууллага	2000 м2	15 жил

2.2. Газрын төлбөрийн хэмжээ:

Нэгжийн үнэ 20 төгрөг/үсгээр _____ /

Газрын төлбөрөөс чөлөөлөгдөх талбай /0м²/, чөлөөлөгдөх хувь /0%/

Бүгд үнэ 40000 төгрөг/үсгээр _____ /

Үүнээс:

1-р улиралд 10000 төг

3-р улиралд 10000 төг

2-р улиралд 10000 төг

4-р улиралд 10000 төг

2.3. Газрын төлбөрийг улирал бүрийн эхний сарын 25-ны дотор газар эзэмшүүлэгчийн Төрийн сан банк дахь 100080000943 тоот дансанд шилжүүлж байна.

2.4. Газар эзэмшүүлэх тухай эрх бүхий Засаг даргын шийдвэр гарсан өдрөөр газрын төлбөр хийх хугацааг тогтооно.

2.5. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр газрын төлбөрийн хэмжээ өөрчлөгдөх тохиолдолд гэрээнд өөрчлөлт оруулна. Ийнхүү газрын төлбөрийг шинэчлэн тогтоолгоогүй бол зохих зардлыг газар эзэмшигч хүлээнэ.

Гурав. Газар эзэмшигчийн эрх

3.1. Гэрээнд заасан зориулалтын дагуу уг газрыг эзэмших, ашиглах;

3.2. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг газар өмчлөгчөөс гаргуулж авах;

3.3. Газарт учирсан хохирлыг гэм буруутай этгээдээр тогтоосон журмын дагуу нөхөн төлүүлэх;

3.4. Газар эзэмшүүлэх тухай шийдвэр гаргасан этгээдийн зөвшөөрөлтэйгээр эрхийн гэрчилгээгээ бусдад шилжүүлэх, барьцаалах;

3.5. Газар эзэмшигч нь газар эзэмшүүлэх тухай шийдвэр гаргасан этгээдийн зөвшөөрөлтэйгээр тухайн газраа бүгдийг нь буюу зарим хэсгийг бусдад ашиглуулж болно.

3.6. Газрын тухай хууль тогтоомж, газар эзэмших гэрээнд заасан үүргээ зохих ёсоор биелүүлж ирсэн бол эрхийн гэрчилгээний хугацаа дуусахад уг газрыг үргэлжлүүлэн эзэмшихээр эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулах /Эрхийн гэрчилгээний хүчин төгөлдөр байх хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө эзэмшигч нь хугацааг сунгуулах тухай хүсэлтээ тухайн шатны Засаг даргад гаргах/;

3.7. Газар эзэмших эрхийн гэрчилгээ хүчингүй болсон тохиолдолд эрхийн гэрчилгээг хүчингүй болгосон Засаг даргын шийдвэрийг эрхийн гэрчилгээ эзэмшигч болон барьцаанд авсан этгээд нь хууль бус гэж үзвэл тухайн шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор шүүхэд гомдол гаргах эрхтэй.

Дөрөв. Газар эзэмшигчийн үүрэг

- 4.1. Газар эзэмших гэрээнд заасан нөхцөл, болзлыг биелүүлэх;
- 4.2. Газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах, байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж болон төрийн эрх бүхий байгууллагаас газар ашиглалттай холбогдуулан тавьсан нийтлэг шаардлагыг биелүүлэх;
- 4.3. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг тогтоосон журмын дагуу хийлгэж байх /5 жилд нэг удаа хийлгэнэ./;
- 4.4. Бусдын газар эзэмшихтэй холбогдсон эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүй байх;
- 4.5. Газрын төлбөрийг газрын ашигт шинж чанарыг ашигласан эсэхээс үл хамааран хугацаанд нь төлөх;
- 4.6. Төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувиар хэтэрсэн хоног тутамд алданги төлөх;
- 4.7. Эзэмшлийн газраа бүхэлд нь буюу зарим хэсгийг бусдад ашиглуулах бол эрх бүхий Засаг даргаас зөвшөөрөл авч, энэ тухай улсын бүртгэлд бүртгүүлэх;
- 4.8. Газар эзэмшүүлэгчээс газрын эзэмшил ашиглалттай холбогдуулан тавьсан шаардлагыг цаг тухайд нь биелүүлэх;
- 4.9. Кадастрын зураглал гүйцэтгэх эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллага, иргэнийг өөрийн эдлэн газартаа саадгүй нэвтрүүлж, ажиллах, мэдээлэл авах боломжоор хангах
- 4.10. Өөрийн эдлэн газрын хилийн эргэлтийн цэгүүдийг газар дээр нь тэмдэглэсэн тэмдэгтийг хамгаалалтандаа авч, бүрэн бүтэн байдлыг хариуцах
- 4.11. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр тавигдсан шаардлагыг биелүүлэх
- 4.12. Эдлэн газрын эргэлтийн цэгүүдийг хөдөлгөсөн, нүүлгэн шилжүүлсэн, устгахгүй байх
- 4.13. Геодезийн байнгын цэг, тэмдэгт байрлаж байгаа газарт барилга байгууламж барих, газар шорооны ажил хийхдээ сум, дүүргийн Засаг дарга буюу хил хамгаалах ерөнхий газраар уламжлан геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авна.
- 4.14. Газар эзэмшүүлэх гэрээг дүгнүүлэх
- 4.15. Барилга байгууламжийн төлөвлөлтийн эскиз зургийг сум болон аймгийн ерөнхий архитектороор батлуулах
- 4.16. Барилга байгууламжийн зураг төсөл нь хот, тосгоны батлагдсан ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний шийдлүүд, олгогдсон газрын хэмжээ, зориулалттай уялдсан байх бөгөөд барилгажих талбай нь тухайн газрын 70 хувиас илүүгүй байна.
- 4.17. Барилгын улаан шугам тавихад Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын геодези зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэнг оролцуулан баталгаажуулах
- 4.18. Гэрээний биелэлт тооцсон дүгнэлтээр илэрсэн зөрчлүүдийг заасан хугацаанд арилгах арга хэмжээ авах
- 4.19. Эзэмшил, ашиглалтанд байгаа болон орчны 50м хүртэлх нийтийн эзэмшлийн зам талбай, ногоон байгууламжид тохижилт, арилчилгаа хийх
- 4.20. Холбогдох хууль тогтоомжоор тогтоосон бусад эрх, үүрэг, хариуцлага хүлээх;

Тав. Газар эзэмшүүлэгчийн үүрэг

- 5.1. Газрыг гэрээнд заасан зориулалтын дагуу эзэмшиж байгаа эсэхийг хянах;
- 5.2. Уг газрыг эзэмшүүлэхийн зэрэгцээ дараахь шаардлагыг газар эзэмшигчид тавих эрхтэй. Үүнд:
 - а. Газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах, байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж болон төрийн эрх бүхий байгууллагаас газар ашиглалттай холбогдуулан тавьсан нийтлэг шаардлагыг биелүүлэх

б. Эзэмшүүлэхээр олгосон газарт зориулалтын бус барилга байгууламж барих, хүн амын амьдрах орчны чанарт сөрөг нөлөө бүхий үйл ажиллагаа явуулахгүй байх

в. Газрыг зориулалтын дагуу эрүүл ахуйн шаардлага хангаж ажиллах

г. Хот тосгоны өнгө үзэмж, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах, газрыг хамгаалах, нөхөн сэргээх шаардлагын дагуу эзэмшилд авсан газрын 10-аас доошгүй хувийг ногоон байгууламжтай байлгана.

д. Барилгын зургийг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлэх ба барилгыг мэргэжлийн байцаагчаар хянуулах

е. Хот байгуулалтын ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөнд өөрчлөлт орсон тохиолдолд газар эзэмших гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авах

5.3. Газрыг гэрээний нөхцөлийн дагуу эзэмшээгүй, энэ талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй буюу Газрын тухай хуулийн 40.1.1-40.1.6 дугаар зүйлд заасан нөхцөл бий болсон тухайлбал:

а. Эрхийн гэрчилгээ эзэмшигч газрын тухай хууль тогтоомж, газар эзэмших гэрээний нөхцөл, болзлыг удаа дараа буюу ноцтой зөрчсөн;

б. Газрыг хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашигласан нь эрх бүхий байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон;

в. Шилжүүлж авсан эрхийн гэрчилгээгээ улсын бүртгэлд бүртгүүлж, шинээр гэрээ байгуулаагүй;

г. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр тавигдсан шаардлагыг биелүүлээгүй; эрхийн гэрчилгээ эзэмшигч газрын төлбөрөө хугацаанд нь бүрэн төлөөгүй;

е. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр* гэрээнд заасан зориулалтын дагуу тухайн газраа 2 жил дараалан ашиглаагүй* зэрэг тохиолдолд гэрээг хүчингүй болгож, мөн хуулийн 62 дугаар зүйлд зааснаар хохирлыг нөхөн төлөхийг шаардах;

ё. Өмнөх гэрээний биелэлтээр илэрсэн зөрчлийг арилгуулах

5.4. Газар эзэмшүүлэх гэрээг жил бүр дүгнэх;

5.5. Холбогдох хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх, үүрэг, хариуцлага хүлээх;

Зургаа. Газрын талаарх эд хөрөнгийн эрхийн зарим зохицуулалт

6.1. Газар эзэмшигчийн эзэмшилд байгаа тухайн газар дээрх үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх өөр этгээдэд шилжвэл газар эзэмших эрх мөн адил шилжих болно гэж шийдвэрлэнэ.

6.2. Энэхүү гэрээгээр эзэмших газрыг хязгаартай эзэмших эрх бүхий газар ашиглагч байгаа болон ийнхүү ашиглахаар шаардсан бол түүний газар ашиглах нөхцөл, журам нь газрын тухай хуулийн 48-р зүйлд заасан нөхцөлийг дагаж мөрдөх болно. Шаардлагатай гэж үзвэл энэхүү гэрээнд хавсаргаж болно.

6.3. Газар эзэмшигчийн газрыг бүхэлд нь буюу зарим хэсгийг гэрээний хугацаа дуусахаас өмнө эрх бүхий байгууллага улсын тусгай хэрэгцээнд нөхөн олговортойгоор солих буюу эргүүлэн авах тухай шийдвэр гаргавал уг шийдвэрийн үндэслэл болсон талуудын урьдчилсан тохиролцоо болон бусад эрхийн актаар зохицуулна.

6.4. Гэрээний талуудын шаардлагатай гэж үзсэн бусад нөхцөл: Эзэмших эрх бүхий газраа зориулалтын дагуу эзэмшээгүй болон газрын төлбөрөө хугацаанд нь төлж барагдүүлаагүй тохиолдолд газар эзэмших эрхийг нь хүчингүй болгох хүртэл арга хэмжээ авч газар дээрх эд хөрөнгийн эрхийн асуудлыг шүүхийн журмаар шийдвэрлэнэ. Мөн зохих зөвшөөрөлгүйгээр газрын хэмжээнд өөрчлөлт оруулсан нөхцөлд газар эзэмших эрхийг цуцлах хүртэл арга хэмжээ авна.

Жич: “хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ...” гэдгийг гэнэтийн давагдашгүй хүчний эсхүл байгалийн тогтолцооны өөрчлөлтөөс тухайн газарт нь эвдрэл, элэгдэл, цөлжилт бий болсон, бусдын хууль бус үйлдэл зэрэг газар эзэмшигчээс хамаарах шалтгаан байхгүй байсныг ойлгоно.

“... зориулалтын дагуу газраа 2 жил дараалан ашиглаагүй” гэдгийг газар эзэмшүүлэх тухай гэрээ хийгдсэнээс хойш хуанлийн бүтэн 2 жилийн дотор газар эзэмшигч нь тухайн газар дээрээ гэрээнд заасан нөхцөл, болзол, зориулалтын дагуу тодорхой үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлээгүй /барилга, байгууламж, зам талбай бариагүй, тариалан эрхлээгүй г. м/ байхыг ойлгоно.

Долоо. Бусад зүйл

7.1. Гэрээ нь газар эзэмшигчид газрыг актаар хүлээлгэн өгч, эрх бүхий Засаг дарга газар эзэмших эрхийн гэрчилгээ олгосон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж мөрдөгдөнө.

7.2. Газар эзэмшүүлэх гэрээг талууд жил бүр дүгнэх ба газар эзэмшигч гэрээний биелэлтийг жил бүрийн 06-р сарын 25-ны дотор багтаан тайлагнаж, газар эзэмшүүлэгч 07-р сарын 01-ний дотор багтаан дүгнэнэ.

7.3. Газар эзэмшүүлэх гэрээг дүгнүүлээгүй, өмнөх гэрээний биелэлт тооцсон дүгнэлтээр илэрсэн зөрчлүүдийг арилгах арга хэмжээ аваагүй, дахин давтагдсан тохиолдолд Газрын тухай хууль тогтоомжийн дагуу газар эзэмших, эрхийн гэрчилгээг хүчингүй болгох саналыг холбогдох албан тушаалтанд уламжлан шийдвэрлүүлнэ.

7.4. Энэхүү гэрээтэй холбоотой бусад асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

7.5. Газар олгох техникийн нөхцөл болон холбогдох мэргэжлийн байгууллагуудын дүгнэлтийн дагуу тухайн газар дээр байрлаж буй инженерийн шугам сүлжээг холбогдох байгууллагаас зөвшөөрөл авсаны үндсэн дээр нүүлгэн шилжүүлэх ба түүнтэй холбогдон гарах зардлыг газар эзэмших эрх авсан байгууллага, аж ахуйн нэгж, иргэн хариуцна.

Гэрээний талуудын албан ёсны хаяг, харилцах утас:

Газар эзэмшүүлэгч;

Дундговь аймгийн Дэлгэрцогт сум

Дундговь аймгийн Дэлгэрцогт сум 3-р баг

Утас: 99845234

Газар эзэмшигч: Соёлын төвийн эрхлэгч Шар овогтой Отгонцэцэг

Газрын байршил: Дундговь Дэлгэрцогт 3-р баг Амардалай-2 207

Газар эзэмшигчийн хаяг: Дундговь Дэлгэрцогт

Регистр / улсын бүртгэл /-ийн дугаар: /9033513/

Банк, дансны дугаар:


Харилцах утас:

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Газар эзэмшүүлэгчийг төлөөлж:

Сумын Газрын даамал

Л.Хулан/...../тамга/



Газар эзэмшигчийг төлөөлж:

Соёлын төв-ны Эрхлэгч Шар овогтой Отгонцэцэг

...../тамга/

/гарын үсэг/...../тамга/

Энэхүү гэрээний нэг хувийг хадгалав.

4811000707 дугаар бүхий нэгж талбарын хувийн хэрэгт